



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 434

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 14 нэрийн, нийт 167,014,934.00 (нэг зуун жаран долоон сая арван дөрвөн мянга есөн зуун гучин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, 49,437,410.28 (дөчин есөн сая дөрвөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун арван төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Соёлын өвийн үндэсний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын дарга С.Болдсайхан, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн ~~15~~ дугаар тогтоолын хавсралт

ЮНЕСКО-ийн МҮК-ийн балансаас Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн
хөрөнгийн дансанд балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Нийт хөрөнгийн дүн (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Хурлын HD камер	1	9,400,440.00	9,400,440.00	3,525,165.00	5,875,275.00
2	Орчуулгын төхөөрөмжийн удирдлага	1	8,593,000.00	8,593,000.00	3,222,374.94	5,370,625.06
3	Дууны гаралтын төхөөрөмж	2	5,639,607.00	11,279,214.00	4,229,705.34	7,049,508.66
4	Орчуулгын радиатор	2	8,166,960.00	16,333,920.00	6,125,220.00	10,208,700.00
5	Орчуулгын кабин	2	35,000,000.00	70,000,000.00	13,125,000.00	56,875,000.00
6	Радиаторын ханын бэхэлгээ	2	171,600.00	343,200.00	64,350.00	278,850.00
7	Хүлээн авагчийн зай	50	654,360.00	32,718,000.00	12,269,250.00	20,448,750.00
8	Нэг чихний хүлээн авагчийн чихэвч	50	41,040.00	2,052,000.00	769,500.00	1,282,500.00
9	Орчуулагчийн микрофон	2	3,135,000.00	6,270,000.00	2,351,250.00	3,918,750.00
10	Орчуулагчийн чихэвч	2	351,120.00	702,240.00	263,340.00	438,900.00
11	Хүлээн авагчийн цэнэглэгч хайрцаг	1	5,289,600.00	5,289,600.00	1,986,600.00	3,303,000.00
12	Хүлээн авагчийн хадгалах хайрцаг	1	1,279,080.00	1,279,080.00	479,655.00	799,425.00
13	Хүлээн авагчийн зай NI-MH	50	54,720.00	2,736,000.00	1,026,000.00	1,710,000.00
14	Кабель coaxial-cable	2	9,120.00	18,240.00		18,240.00
		168		167,014,934.00	49,437,410.28	117,577,523.72
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	168 (нэг зуун жаран найм)		167,014,934.00 (нэг зуун жаран долоон сая арван дөрвөн мянга есөн зуун гучин дөрвөн)	49,437,410.28 (дөчин есөн сая дөрвөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун арван төгрөг хорин найман мөнгө)	117,577,523.72 (нэг зуун арван долоон сая таван зуун далан долоон мянга таван зуун хорин гурван төгрөг далан хоёр мөнгө)